

Сангийн яамны 100 жилийн ойд**МОНГОЛ УЛСАД САНХҮҮГИЙН АЛБА ҮҮСЧ ХӨГЖСӨН НЬ***Д.Моломжамц***Л.Хайсандай***

Манжийн түргэмгийлэгчдийн эсрэг тэмцсэн Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911 онд Монгол Улсад үндэсний хувьсгал гарч, тусгаар тогтносон улс байгуулсныг зарласан тэр цагаас хойш 100 жил болж байна. 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд хаант Монгол улсын шашин, төрийг хосолсон хаанаар 8 дугаар Богд Жавзандамба хутагтыг өргөмжилсөн байдаг билээ.

Богд хааны бараг эхний зарлигаар тусгаар тогтносон хаант Монгол улсын засгийн газрыг байгуулан түүний 5 яамыг байгуулсны нэг нь Сангийн яам байжээ. Мөн энэ үйл явдлын дараахан Бүгд ерөнхийлөн захирах сайд буюу ерөнхий сайдаар Сайн ноён хан Намнансүрэнг томилж, төрөө төвхинүүлж, тусгаар тогтносон улсын хувьд байх ёстой төрийн бүхий л тогтолцоог бий болгох ажилд орсон ажээ. Тэр үеийн түүхийн зарим материалуудаас үзэхэд ерөнхий сайд Сайн ноён Намнансүрэн тэргүүтэй засгийн газар нь өөрийн үйл ажиллагааг хоёр үндсэн чиглэлээр өрнүүлсэн болох нь харагдаж байна.

Төрөө төвхинүүлэхийн тулд юуны түрүүнд Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх талаар олон улсын түвшинд ажиллах, үүнтэй холбогдуулан хаант Оросын засгийн газарт хандаж улс төр, цэргийн болон эдийн засгийн тусламж хүсэхээс ажиллаж эхэлсэн байдаг. Засгийн газрын ажлын хоёр дахь чиглэл нь улсын дотоодлоо тусгаар тогтнолоо хамгаалах, бэхжүүлэх, тусгаар тогтносон улсын хувьд байх ёстой төрийн бүхий л билэг тэмдэг, тогтолцоог бий болгон төрөө төвхинүүлэх явдал байжээ. Эдгээр арга хэмжээний дотор улсын сан хөрөнгийг бий болгох, төсөв зохиох, татвар хураах, хил, гаалийн ажлыг эмхлэн зохион байгуулах олон асуудлууд Сангийн яамны өмнө тулгарсан байна. 1912 оноос төсөв зохиох ажилд орсон хэдий ч нүүдлийн тархай бутархай аж ахуй бүхий эдийн засгийн бүтэц хийгээд санхүүгийн боловсон хүчин дутагдалтай байсан зэрэг тухайн үед учирсан олон хүндрэлтэй байдлаас болоод улсын хэмжээний нэгдсэн төсвийг зохиож чадаагүй зөвхөн засгийн газрын төсвийг боловсруулан зохиож байжээ.

1913 оны улсын төсвийг авч үзвэл, орлого 757418 рубль болж, түүний 60 гаруй хувь татвар, хураамжаас, 15 хувь түрээсийн төлбөр, 5 орчим хувь алтны уурхайн орлогоос бүрдэж байжээ. Төсвийн зарлагын

* Д.Моломжамц - Сангийн сайд асан, эдийн засгийн шинжлэх ухааны доктор

** Л.Хайсандай - ШУА-ийн ОУСХ-гийн захирал, доктор (Sc.D), профессор

40 гаруй хувийг цэргийн зардал, 20 гаруй хувийг захиргааны зардал эзэлж байсан байна.

Манжийн дарлалын үед Монгол Улс Манжид маш их өртэй байсан бөгөөд 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал ялах үед өрийн хэмжээ 15 сая рубльд хүрсэн байсан ба Засгийн газрын шийдвэрээр уг өрийг хүчингүй болгожээ.

Засгийн газрын төсвийн орлого нь гол төлөв феодалууд болон ардуудаас хураах татвар, гаалийн татвар болон гадаадын пүүс компаниас төлөх татвар болон гадаадаас авсан зээлээс бүрдэж байв. Төсвийн зарлага нь засгийн газрын зардал, цэрэг, хилийн хамгаалалт болон Богд хааны зардалд зориулагдаж байжээ. Засгийн газрын төсөв нь алдагдал байсан ба түүнийг гадаадын зээлээр гол төлөв Хаант Оросын засгийн газраас авсан зээлээр нөхөж байсан ажээ. 1915 оны улсын төсвийн зарлагын 83 хувийг засгийн газрын байгууллагуудын санхүүжилт болон Богд хааны шашны үйл ажиллагааны зардалд зарцуулж байжээ.

1912 оны 10 дугаар сард Засгийн газрын шийдвэрээр Сангийн яамны дэргэд Гаалийн хэрэг эрхлэх яамыг байгуулж, гааль, татварын асуудлыг хариуцуулсан байна. Мөн улсын хилийн дагуугаалийн 37 хороо байгуулж, улсын хилээр оруулах болон гаргах бүх бараанаас гаалийн татвар авах болсон нь засгийн газрын төсвийн орлогын нэг чухал эх үүсвэр болжээ. Тухайлбал, гадаадад гаргах мал, малын гаралтай түүхий эдээс болон гадаадаас оруулж ирэх элдэв бараа, эд зүйлийн үнийн 5 хувь, архи тамхины үнийн 10 хувиар гаалийн татвар ногдуулан төсөвт оруулж байжээ.

Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд засгийн газарт санхүүгийн хөрөнгө төвлөрүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгттэй болох, үндэсний банк байгуулах зэрэг олон арга хэмжээ авах шаардлагатай болохыг Монголын Засгийн газар сайн ойлгож байсан хэдий ч дотоодын санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байжээ. Иймээс Хаант Оросын засгийн газарт хандаж зээл олгохыг хүссэн байдаг билээ.

Монгол улсын ерөнхий сайд Намнансүрэнгийн Хаант Орос улсад 1913 онд хийсэн албан ёсны айлчлалын үеэр яригдсан улс төр, цэргийн зэрэг олон асуудлын дотор хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал чухал байр эзэлж байсан байна. Манай хүсэлтийн дагуу Хаант Оросын засгийн газраас Монголын засгийн газарт 3,0 сая рублийн зээл олгохоор шийдвэрлэсэн байдаг бөгөөд үүний 2 сая рублийг 1913 оны 1 дүгээр сард авсан байдаг юм.

Мөн энэ айлчлалын үед Монголд банк байгуулахад Хаант Оросын засгийн газар тусламж үзүүлэх талаар зарчмын тохиролцоонд хүрсэн бөгөөд энэ дагуу Монгол улсын засгийн газрын албан ёсны зөвшөөрлийн дагуу Монголын Үндэсний банк гэдэг нэр бүхий Сибирийн худалдааны банкны салбарыг 1914 онд нийслэл Өргөө хот

буюу одоогийн Улаанбаатар хотод нээн ажиллуулж байжээ. Тус банк нь Монгол дахь оросын иргэд, пүүсүүдэд үйлчлэхээс гадна Монголын засгийн газар хийгээд монголын феодал, ноёдуудад зээл олгож байсан юм. Тус банк нь тухайн үедээ Монголын засгийн газарт дэмжлэг үзүүлж байсан төдийгүй манай улсад санхүү-зээлийн систем үүсч хөгжихэд чухал түлхэц болсон нь тодорхой. Иймээс манай улсад үндэсний банк байгуулагдсаны түүхийг 1914 оноос эхэлсэн гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Ийнхүү Монгол улс 1911 онд өөрийн тусгаар тогтнолыг зарлаж, автономит эрхтэй байсан хэдий ч бие даасан тусгаар улс болж хөгжих замд орж байсан энэ үед буюу 1911-1914 онуудад манай улсад санхүү-зээлийн систем үүсэн хөгжих эхлэл тавигдсан байна.

1921 оны ардын хувьсгал нь Монголын нийгэм, эдийн засгийн байдлыг үндсээр нь өөрчлөхөд хүргэсэн түүхэн үйл явдал болсон бөгөөд Монгол Улсын санхүү-зээлийн системийн хөгжилд шинэ хуудсыг нээсэн юм. Ардын хувьсгалын үр дүнд МАН-ын байгуулсан засгийн газрын авч хэрэгжүүлж эхэлсэн эхний арга хэмжээний дотор санхүү, төсөв, гааль, татвар, банк зэрэг олон асуудал чухал байр эзэлж байв.

Мөнгөний эргэлтэд тавих хяналтыг сайжруулах, гадаадын пүүс, компаниас албан татварыг бүрэн хурааж байх зорилгоор 1921 оны 7 дугаар сард Засгийн газрын тогтоол гарч гүйлгээнд зөвхөн оросын рубль, хятадын янчаан болон ланг хэрэглэж байхаар шийдвэрлэж, тэр үед Монголын зах зээл дээр арилжаалагдаж байсан гадаадын бусад валютын гүйлгээг хориглосон байна.

Гүйлгээнд хэрэглэхийг зөвшөөрсөн гадаадын мөнгөн тэмдэгтүүдийн оросын жижиг цагаан мөнгөтэй харьцах тооцооны жишиг ханшийг түр тогтоож хэрэглэх болсон нь гаднын пүүсүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, татварыг зөв оногдуулах, улсын сан хөрөнгийг аривжуулахад чиглэсэн арга хэмжээ байжээ. Жишээ нь 1 рубль 250 орос цагаан мөнгөтэй, 1 янчаан 350 орос цагаан мөнгөтэй, 1 лан 500 орос цагаан мөнгөтэй тус тус дүйцэх солилцооны ханш тогтоосон байна. Эдгээр солилцооны ханшийг үндэслэн 1921 оноос эхлэн Ардын засгийн газар улсын төсвийг зохиох болжээ. Улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос мексик доллароор хийж байжээ.

1921 оны 9 сард Улсын бага хурлын шийдвэрээр автономитын үеийн татварын тогтолцоог өөрчилж, бүх аж ахуйн нэгжид ижил мөрдөх ашиг орлогын болон эд хөрөнгийн өсөн нэмэгдэх шатлал бүхий татварыг бий болгосон ажээ. Сангийн яам улсын албан татварын дүрмийг боловсруулан 1922 оны 3 сарын 14-нд Улсын Түр Цагийн хурлаар батлуулан мөрдөх болжээ. Мөн Улсын санд халх 4 аймаг, шавь таван газраас мөнгөөр албан татвар журам боловсруулж батлуулсаны дээр аймаг, шавьд татвар эрхлэх газар байгуулж, татвар хураах болсон нь улсын төсвийн орлогын эх

үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ болсон төдийгүй яваандаа орон нутгийн төсөвтэй болох эхлэл болжээ.

1923 оны 6 дугаар сарын 18-нд болсон МАН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаас баталсан “Эдийн засгийн үндсэн бодлого” баримт бичигт ойрын жилүүдэд баримтлах эдийн засгийн бодлого тусгалаа олжээ. Татварын бодлогын талаар энэхүү баримт бичигт “...албан татвар хураахад эрхтэн дархтан, лам, хар, аймаг, шавь, жас сүрэг гэж ялгаварлахгүйгээр цөм хүний чадал ба хөрөнгө зузаатах тусам татвар гувчуурыг өсгөн хураавал зохино. Улсын сан ба орон нутгийн хэрэгт зориулсан орлого, зарлагын зүйлийг эрхбиш эсэргэн жилийн нь урьдаас төсөөлж өнгөрсөн жилийн хойно тайлж, төсөөлөн тайлсныг дээд газраас хянан тогтоолгож байвал улс дотор аливаа албан татвар, орлого, зарлагын зүйл эмхтэй болно...” гэж дурдсан нь төсөв, татварын талаар хийх ажлын чиглэл байв.

1923 онд худалдааны нэгдсэн татвар тогтоож, гадаадын пүүсүүд, мөн улсын болон хувийн үйлдвэр, аж ахуйн худалдааны гүйлгээнээс татвар авах болсон байна. 1925 онд анх ашиг орлогын татварыг бий болгож, улсын албан хаагчдын цалин болон худалдаа, тээвэр зэрэг улсын, хоршооллын болон хувийн өмчийн бүх салбарт ажиллаж байгаа бүх хүмүүсийн орлогоос татвар авах болжээ. 1926 онд мал аж ахуйн албан татварын шинэчлэл хийж, малчин ард, ноёд, феодалын малд ногдуулах нэгдсэн татварын тогтолцоог бий болгосон байна.

Гаалийн орлого нь төсвийн орлогын чухал эх үүсвэр байсан бөгөөд Богд хаант Монгол улсын засгийн газрын гаалийн татварын хэмжээг бараг өөрчлөхгүй мөрдөхөөр шийдвэрлэж байжээ. Сангийн яамны дэргэд гаалийн алба байгуулж, гаалийн татвартай холбогдсон бүх асуудлыг хариуцах болжээ.

1926 онд УИХ-аас орон нутгийн төсвийн дүрэм баталж, улмаар 1927 оноос улсын нэгдсэн төсвийг зохиож батлах болжээ. Ийнхүү 1927 оноос улсын төсөв нь Монгол улсын төрийн тогтолцоонд нийцэн засаг, захиргааны бүгцэд тулгуурласан улсын болон орон нутгийн төсвөөс бүрдэх болсон байна. Улсын төсвийн жилийг цагаан сарын он тоололоор тооцож байсныг өөрчилж, 1925 оноос аргын улирлын цаг тоололын дагуу зохиох болжээ.

Ийнхүү 20-иод оны эцэс гэхэд Монгол улсын засгийн газар татварын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, автономит Монголын үед байсан татварын тогтолцоог ихээхэн өөрчилж, төсвийн орлогын тогтвортой үндсэн эх үүсвэрийг бий болгож чадсан байна. Төсөв, татварын бодлого нь МАН-ын болон засгийн газрын эдийн засгийн бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болж, улсын эдийн засгийн байдлын бие даасан байдлыг дээшлүүлэх, эдийн засгийн суурь болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, малын тоо толгойг өсгөх, гадаадын капиталыг улсын эдийн засгаас шахан гаргахад чиглэх болжээ.

Санхүүгийн системийн хөгжилд гарсан нэг том өөрчлөлт нь Монгол-Оросын хамтарсан худалдаа, аж үйлдвэрийн банкыг 1924 онд байгуулж, мөнгөн гүйлгээний ажлыг журамлах, банкны зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх болсон явдал юм. Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкны Монголын талын хувь нийлүүлэгч нь Сангийн яам, Оросын талынх нь ЗХУ-ын Сангийн яам байжээ. Үүний дараа Сангийн яамны Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комисс боловсруулсан мөнгөний шинэчлэл хийх саналыг Засгийн газар зөвшөөрч, улмаар Улсын Бага хурлаар баталсан байна. Мөнгөний шинэчлэлийн хүрээнд 1928 онд Монголын үндэсний валют-төгрөгийг гүйлгээнд гаргаж, банкны төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх болсны зэрэгцээ Монгол банк нь эмиссын төв болж, улмаар улсын төсвийн орлого, зарлагын гүйлгээ хийх болсон байна. Ийнхүү үндэсний банк байгуулж, өөрийн үндэсний мөнгөн тэмдэгтэй болсон нь санхүү-зээлийн системийн хөгжилд гарсан том өөрчлөлт төдийгүй улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нэг чухал баталгаа болсон юм.

Санхүүгийн системийн хөгжлийн дараахь үе нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн аргаар эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх буюу социалист хөгжлийн замыг сонгосон 1940-1990 оныг хамарч байна. 1940 онд хуралдсан МАХН-ын 10 дугаар их хурлаас намын эдийн засгийн бодлогын үндсэн чиглэл нь социалист нийгмийг байгуулах, энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд улс ардын аж ахуйг төвлөрсөн төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн явдал юм. Улсын өмчийг бүхий л талаар дэмжих, үйлдвэр, аж ахуйн газарт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах төлөвлөгөөт даалгавар өгөх, хөдөө аж ахуйн нэгдлүүдэд улсын төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлэх бэлтгэлийн зүйлийн даалгавар өгөх болов. Мөн олох ашиг, хуримтлалын болон өртөг зардал хямдруулах, чанар дээшлүүлэх норматив үзүүлэлтүүдийг тогтоон өгч, үйлдвэрийн газрын ашигаас шинэ төрлийн татвар авч төсвийн орлогыг бүрдүүлэх болов.

Улсын төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг зохиох, биелэлтийг зохион байгуулах ажил үйлдвэр, аж ахуйн газрын төлөвлөгөөний биелэлтээс шууд хамаарах болов. Үйлдвэр, аж ахуйн газраас улсын төсөвтэй харилцах харилцаанд зарчмын өөрчлөлт орж, төсвийн орлогын дийлэнхийг улсын үйлдвэр, аж ахуйн газрууд бүрдүүлэх болсон байна. Улсын үйлдвэрийн газруудаас ашгийн шимтгэл, фондын төлбөр, ялгаварт рент зэрэг шинэ татвар хураах журамд шилжиж, өмнө нь байсан төсвийн орлогын хэд хэдэн татварыг байхгүй болгожээ. Гаалийн болон худалдааны татварыг өөрчилж, оронд нь гүйлгээний татвар авах журамд шилжсэн байна.

Мөн хувийг өмч дээр тулгуурласан аж ахуйн нэгжийг улсын болгох, нийгэмчлэх үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулж, зөвхөн хоршоолсон өмчийг хөдөө аж ахуйн нэгдлүүдийн үйл ажиллагаагаар хязгаарлан үлдээсэн ажээ. Хөдөө аж ахуйн нэгдлүүдийг улсаас дэмжихэд

их анхаарч, улсын бэлтгэлийн үнийг удаа дараа нэмэгдүүлэх, нэгдлийн гишүүн малчдыг улсын нийгмийн даатгалын системд хамруулах болжээ. Хөдөө нэгдлүүдийн улсын төсөвт төлөх татварын хувь хэмжээг бууруулж, ашгийн шимтгэл хэлбэрээр авч байсан татварыг өөрчилж, ашиг орлогын татвар болгожээ. Ийнхүү 60-аад оны эхэн гэхэд манай улсын санхүү - зээлийн систем нь социалист нийгэм байгуулах, эдийн засгийг төвлөрсөн төлөвлөгөөний дагуу удирдах зарчимд бүрэн захирагдсан, түүнд үйлчлэх нэг гол механизм болсон байна.

Дараагийн жилүүд буюу 1990 он хүртэл манай улсын эдийн засгийн хөгжлийн чиглэл нь төлөвлөлтийг боловсронгуй болгох, аж ахуйн харилцааг төгөлдөржүүлэх замаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэж байсан бөгөөд энэ хүрээнд эрэл хайгуулын шинж чанартай олон арга хэмжээ авч байсан юм. Үйлдвэр, аж ахуйн газруудыг төлөвлөлт, эдийн засгийн урамшуулалын шинэ системд шилжүүлж, тэдний ажлын эцсийн үр дүнгийн талаар эдлэх эрхийг өргөтгөх, бие даасан байдлыг дээшлүүлэх, хүлээх үүргийг өндөржүүлэхэд бүхний анхаарлыг чиглүүлж байжээ.

Үйлдвэр, аж ахуйн газраас улсын төсөвтэй харилцах харилцааг нилээд өөрчилж, ашгийн шимтгэлийн оронд тэдгээрийн ашгаас фондын төлбөр, ялгаварт рент, ашгийн татвар зэрэг шинэ төлбөрүүдийг төсөвт авах болжээ. Энэ дагуу улсын төсвийн орлого, зарлагын бүтэц ч ихээхэн өөрчлөлт орж, улсын төсвийн орлого нь үндсэндээ улсын үйлдвэр аж ахуйн газраас төсөвт төлөх татвараас бүрдэх болжээ. 1989 оны Монгол Улсын төсвийн нийт орлогын бүтцийг авч үзвэл, нийт орлогын 93 хувийг улсын үйлдвэр, аж ахуйн газраас орох орлого болон гадаадын зээл, тусламжийн орлого эзэлж, нийгмийн даатгалын орлого 3,6 хувь, хүн амаас хураах орлогын татвар 0,7 хувь, бусад орлого 3,7 хувийг тус эзэлж байжээ. 1989 оны Улсын төсвийн зарлагын бүтцийн тухайд гэвэл нийт зарлагын 47,1 хувийг материаллаг үйлдвэрлэлийн салбарын санхүүжилт, 36,8 хувийг нийгмийн арга хэмжээний зардал, 8,5 хувийг батлан хамгаалах зардал, 4,7 хувийг улсын удирдлагын зардал эзэлж байжээ. Ийнхүү тухайн үед төрийн эрхэнд байсан улс төрийн хүчний бодлогын илэрхийлэл нь улсын төсөвт тусгалаа олсон байна.

Монгол Улсын нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, зах зээлийн эдийн засгийн зарчмаар хөгжих болсноор манай улсын санхүүгийн системийн хөгжлийн шинэ үеийн түүх эхэлдэг билээ.

Санхүүгийн харилцаанд гарч байгаа өөрчлөлтийг тусгаж, Засгийн газрын тогтоолоор Сангийн яамны дүрмийг 1991 онд шинэчлэн баталж, эдийн засгийг төрийн бодлогод нийцүүлэн удирдаж, дотоод нөөц бололцоог бүрэн ашиглах зарчмыг хэрэгжүүлэх үндсэн дээр хуримтлал нэмэгдүүлэн, улсын санхүүгийн нөөцийг аривжуулж, улс орны санхүүгийн тэнцвэрийг хангах явдлыг тус яамны үндсэн зорилт болгосон байна. 1993

онд Улсын Их хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд яамдын ажлын хүрээг тодорхойлж, сайдын хариуцах ажлыг хуульчлан тогтоосон байна. Үүний дагуу 1994 онд Засгийн газрын тогтоолоор яам, тусгай газрын нийтлэг дүрмийг баталж, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоож өгөхдөө Сангийн яаманд: Улсын төвлөрсөн төсвийн төслийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, төсвийн орлого, зарлагын бүтэц, бүрэлдэхүүнийг боловсронгуй болгох, улсын гадаад, дотоод өрийн асуудлыг зохицуулах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, санхүүгийн хяналт шалгалт явуулах, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл гаргах арга зүйг боловсронгуй болгох, олон улсын санхүүгийн байгууллагатай харилцах ажлыг эрхлэх зэрэг асуудлыг хариуцуулсан байна.

Төсвийн эрхийн тухай хуулийг өөрчилж, 1992 оны сүүлээр УИХ-аас баталсан Монгол Улсын төсвийн тухай шинэ хуулиар зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх улсын төсөв зохиох, хянах, батлах, төсвийн орлогыг бүрдүүлэх, төсвийн хөрөнгийг хуваарилах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах болжээ. Энэ хугацаанд төсвийн тухай хуульд хэд хэдэн өөрчлөлт оруулсан байна.

Зах зээлийн харилцааны жишигт нийцсэн үндэсний татварын шинэ тогтолцоо бүрэлдэн бий болсон явдал өнгөрсөн хорь гаруй жилийн дотор санхүүгийн салбарт хийгдсэн томоохон шинэчлэлтийн нэг мөн. Монгол Улсын Их Хурлаас 1992 онд татварын ерөнхий хууль баталж, түүнийг 1993 оноос мөрдөх болсон нь татварын шинэ тогтолцооны эрх зүйн үндсийн эхлэл байв. УИХ-аас татварын хууль тогтоожмжийг боловсронгуй болгож, татварын багц хуулиудын шинэчилэн баталж мөрдүүлжээ.

Төсөв, татварын шинэчлэлийг зах зээлийн зарчимд нийцүүлэх ажлын хүрээнд төсвийн орлого, санхүүжилтийн шинэ журам болох Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд 2002 оны долдугаар сарын 1-нээс шилжсэн нь төсвийн бодлогод гарсан том өөрчлөлт юм. Энэ тогтолцооны гол агуулга нь төсвийн санхүүжилт хийх, орлого төвлөрүүлэх ажлыг арилжааны банкаар бус төрийн сан дахь дансаар дамжуулан хэрэгжүүлэх болсон явдал юм.

Өнгөрсөн хорь гаруй жилийн дотор Монголын эдийн засаг үндсэндээ хувийн хэвшилд тулгуурласан бүтэцтэй болж, санхүү, банк, татвар, нийгмийн даатгал, үнийн систем, тэтгэвэрийн тогтолцоог үндсээр нь өөрчилж чадсаны үр дүнд төсвийн орлого, зарлагын бүтэц, бүрэлдэхүүн зах зээлийн орнуудын нийтлэг жишигт нийцсэн байна.